



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/107/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэгмиддорж
Утас: 261205 Цахим хаяг: tsegmeddorjd@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул Аудит ХХК-ийн
захирал Ч.Мөнхтуяа
Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	14
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТӨХХК	Төрийн өмчим хязгаарлагдмал хариуцлагатай компани
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНБОАТ	Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БЯМБАСҮРЭН ТАНАА

2023.03.15 № 07/565
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 225.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд: Өр төлбөрийн 650.8 сая төгрөг, авлагын 752.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 96.4 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа зэрэг болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний газраас 2013 онд "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-д балансаас балансад шилжиж ирсэн 392.7 сая төгрөгийн авлага, "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-с шилжиж ирсэн 257.02 сая төгрөгийн авлага, Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ, зураг төслийн судалгаа хийхтэй холбоотойгоор 1992 онд үүссэн 3,731.1 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орлогыг 1,347.0 сая төгрөгөөр, зардлыг 1,327.2 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 18.0 сая төгрөг байхаар тогтоосон байна. Гүйцэтгэлээр 1,536.8 сая төгрөгийн

орлого бүрдүүлж, 1,471.5 сая төгрөгийн зардал гарган, 65.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 318 дугаар тогтоолоор Эрчим хүчний хөгжлийн төв ААТТӨҮГ болон Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын нийлүүлэн Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК болгон өөрчлөн байгуулсан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 9-р сарын 16	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	257,762,045.46	1,287,543,755.91
1.1.2	Дансны авлага	1,084,900,485.96	1,124,159,873.42
1.1.4	Бусад авлага	1,799,423.00	14,760.00
1.1.6	Бараа материал	358,280,392.50	369,264,286.67
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,745,290.04	10,547,012.15
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,712,487,636.96	2,791,529,688.14
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,150,572,817.31	8,884,546,138.34
1.2.2	Биет бус хөрөнгө	4,950,000.00	15,346,273.97
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	11,652,800,800.00	12,884,359,100.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,808,323,617.31	21,784,251,512.31
1.3	Нийт хөрөнгийн дүн	22,520,811,254.27	24,575,781,200.46
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	392,396,347.31	433,938,361.04
2.1.1.2	Цалингийн өглөг	6,361,491.10	2,113,441.87
2.1.1.3	Татварын өр	2,067,382,945.26	2,338,462,257.50
2.1.1.4	НДШ - ийн өглөг	183,437,544.77	183,183,571.03
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	36,681,630.00	493,177,709.90
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,686,259,958.44	3,450,875,341.33
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,417,370,098.44	7,181,985,481.33
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	3,300,991,177.74	3,300,991,177.74
2.3.1	-төрийн	3,300,991,177.74	3,300,991,177.74
2.3.2	-хувийн	0.0	0.0
2.3.3	-хувьцаат	0.0	0.0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,019,474,302.61	3,019,474,302.61
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	12,796,181,934.70	14,027,740,234.70
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,013,206,259.22)	(2,954,409,995.93)
2.3.11	Эздийн өмчийн дүн	16,103,441,155.83	17,393,795,719.12
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	22,520,811,254.27	24,575,781,200.45

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	1,530,111,933.07
2	Борлуулалтын өртөг	0.00	4,165,616.29
3	Нийт ашиг (алдагдал)	0.00	1,525,946,316.79
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.00	1,446,440,263.01
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	6,706,461.15
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(20,883,333.50)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.00	65,329,181.43
19	Орлогын татварын зардал	0.00	6,532,918.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0.00	58,796,263.29
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	58,796,263.29
24	Орлогын нийт дүн	0.00	58,796,263.29
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2022 оны 09-р сарын 16-ны үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	12,796,181,934.70	(3,013,206,259.22)	16,103,441,155.83
Залруулсан үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	12,796,181,934.70	(3,013,206,259.22)	16,103,441,155.83
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	58,796,263.29	58,796,263.29
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	1,231,558,300.00	0.0	1,231,558,300.00
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	14,027,740,234.70	(2,954,409,995.93)	17,393,795,719.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1.0	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	0.00	2,035,899,263.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	2,024,016,414.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	11,882,849.35
1.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	1,006,117,552.91
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.00	495,213,048.23
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.00	153,036,096.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	31,898,895.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	16,115,415.84
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	19,626,931.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	0.00	290,227,166.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	1,029,781,710.44
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	1,029,781,710.44
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	257,762,045.46
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.00	1,287,543,755.91

**Эрчим хүчний үндэсний төв төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	2021 оны гүйцэтгэл	2022 оны 4-р улирал		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	-	1,347,107.4	1,536,818.4	(189,711.0)	114
	Захиалагчийн техник хяналтын орлого	-	746,856.8	777,436.7	(30,579.9)	104
	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	-	159,593.5	758,086.7	(598,493.2)	475
	Гадаад зээл тусламж болон хувийн хөрөнгөөр /Улсын төсвөөс бусад хөрөнгөөр/	-	587,263.3	19,350.0	567,913.3	3
	Зураг төсөл магадлалын орлого	-	200,000.0	327,723.0	(127,723.0)	164
	Сэргээгдэх эрчим хүчний орлого	-	121,750.6	45,887.0	75,863.6	38
	Лабораторийн үйл ажиллагааны орлого	-	100,000.0	83,624.1	16,375.9	84
	Тусгай зөвшөөрлийн орлого	-	40,000.0	103,700.0	(63,700.0)	259
	Техникийн нөхцлийн орлого	-	-	34,240.9	(34,240.9)	-
	Сургалтын орлого	-	100,000.0	125,015.6	(25,015.6)	125
	Түрээсийн орлого	-	19,500.0	23,325.5	(3,825.5)	120
	Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	-	19,000.0	15,865.7	3,134.3	84
2	Нийт зардал	-	1,327,184.0	1,471,489.2	(144,305.2)	111
3	Татварын өмнөх ашиг (алдагдал)	-	19,923.5	65,329.2	(45,405.8)	328
4	Цэвэр ашиг (алдагдал)	-	17,931.1	58,796.3	(40,865.2)	328
5	Нийт авлага	-	952,846.5	1,124,174.6	(171,328.1)	118
	Үүнээс: Найдваргүй	-	392,733.6	392,733.6	-	100
6	Нийт өр төлбөр	-	6,465,403.0	7,181,622.0	(716,219.0)	111
	Богино хугацаат өр төлбөр	-	2,734,292.9	3,450,511.9	(716,219.0)	126
	Урт хугацаат өр төлбөр	-	3,731,110.1	3,731,110.1	-	100
7	Нийт ажиллагсдын тоо	-	94.0	94.0	-	100
8	Нийт цалингийн сан	-	554,232.7	554,444.0	(211.4)	100
9	Нэг ажилтны дундаж цалин	-	1,965.4	1,966.1	(0.7)	100
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	-	1.0	1.0	0.0	97
11	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжин, Сэргээгдэх эрчим хүчийг сурталчлан таниулах, нэвтрүүлэх, Үндэсний хэмжээнд аюулгүй ажиллагааг эрхэмлэгч эрчим хүчний салбарын тэргүүлэгч байгууллага болох"-д оршино гэж тодорхойлсон байна.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах;
- Салбарын хэмжээнд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, ажлыг зохион байгуулах, мэргэшлийн зэргийг аттестатчилах арга хэмжээг зохион байгуулах;
- Цахилгаан болон дулаанжуулалтын тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор түлш, уур-ус, тос, металл судлал, гагнуурын хяналт шинжилгээ хийх, техникийн дүгнэлт гаргах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах;
- Эрхэлсэн асуудлаараа хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;
- Компани техник хяналт тавигдсан эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт, зураг төсөв, холбогдох материалаар мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, сонирхогч байгууллага, иргэдэд энэ талын мэдээллээр хангах;
- Компанийн үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх.

Тайлант оны онцлог үйл ажиллагаа:

- Монгол улсын Засгийн гзарын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 318 дугаар тогтоолоор Эрчим хүчний хөгжлийн төв ААТТӨҮГ болон Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын нийлүүлэн Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК болгон өөрчлөн байгуулсан.
- Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолоор удирдлага, зохион байгуулалтын бүтцийг батлуулж ажилласан.
- Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/238 тоот тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин баталсан;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлийн тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Барилгын тухай хууль;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1,287,543.8	1,287,543.8
Авлага		1,124,174.6	1,124,174.6
Бараа материал		369,264.3	369,264.3
Урьдчилаа		10,547.0	10,547.0
Үндсэн хөрөнгө		8,884,546.1	8,884,546.1
Биет бус хөрөнгө		15,346.3	15,346.3
Бусад эргэлтийн бус хөрөнгө		12,884,359.1	12,884,359.1
Нийт хөрөнгийн дүн		24,575,781.2	24,575,781.2
Богино хугацаат өглөг		3,450,875.3	3,450,875.3
Урт хугацаат өглөг		3,731,110.1	3,731,110.1
Эздийн өмч		17,393,795.7	17,393,795.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		24,575,781.2	24,575,781.2

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,287.5 сая төгрөг нь Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 22.0 сая төгрөг, Арилжааны банкны төгрөгийн дансны үлдэгдэл 1,083.4 сая төгрөг, долларын дансны үлдэгдэл 182.1 сая төгрөг байна.
- Авлага дансны үлдэгдэл 1,124.2 сая төгрөгийн 365.8 сая төгрөг нь 2014 онд үүссэн ажилчдын орон сууцны барилгатай холбогдон үүссэн "Түмэн алт" ХХК-ний авлага бөгөөд 3 шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 183/ГХ2022/01304 тоот Шүүхийн гүйцэтгэх хуудсанд төлбөр төлөгч Түмэн алт ХХК-аас 356.65 сая төгрөгийг гаргуулан Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-т олгохоор шийдвэрлэсэн тул уг шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн байна. 392.7 сая төгрөг нь 2013 онд Эрчим хүчний газраас "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-д балансаас балансад шилжиж ирсэн анхан шатны материалын бүртгэлгүй буюу гэрээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажигдаагүй, хэзээ хэрхэн үүссэн

журналын бичилтгүй тул баримтын бүрдэл хангагдахгүй гэдэг шалтгаанаар шүүхэд өгөх боломжгүй авлага байна. 257.02 сая төгрөг нь Эрчим хүчний сайдын 2022 оны 10 сарын 25-ний өдрийн А/215, А/218, А/219 тоот тушаалуудын дагуу Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүссэн хуримтлагдсан өр авлагын тооцоог “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-с “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-д шилжиж ирсэн авлага байна.

- Урьдчилгаа дансны үлдэгдэл 10.5 сая төгрөг нь Петровис ХХК-тай байгуулсан гэрээний дагуу байгууллагын шатахууны картын үлдэгдэл байна.
- Урт хугацаат өр төлбөр дансны 3,731.1 сая төгрөг нь Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ, зураг төслийн судалгаа хийхтэй холбоотойгоор 1992 онд Засгийн газар Азийн хөгжлийн банктэй хийгдсэн дамжуулан зээлдэх гэрээний өр төлбөр ба энэ нь Эрчим хүчний газраас 2012 онд “ЭХХТ” ТӨҮГ-т балансаас балансад шилжиж ирсэн. Уг урт хугацаат зээлийг Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12 -ний өдрийн хуралдааны шийдвэрээр байгуулагдсан “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХК-д шилжүүлэх асуудал дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.
- Богино хугацаат өглөг дансны үлдэгдэл 3,450.9 сая төгрөгийн 2,338.5 сая төгрөг нь татварын байгууллагат төлөх, Нийгмийн даатгалын шимтгэлийн 183.2 сая төгрөг, ажилчдад өгөх 157.9 сая төгрөг, бусад байгууллагад өгөх 771.3 сая төгрөгийн өглөг байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/238 тоот тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,347.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,327.2 сая төгрөгөөр, ашгийг 18.0 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 1,536.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,471.5 сая төгрөгийн зардал гарган, 65.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,536.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 189.7 сая төгрөг буюу 14 хувиар өссөн нь зураг, төсөл магадлалын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,471.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 144.3 сая төгрөг буюу 11 хувийн илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй байна.

Тайлант онд цэвэр ашиг 58.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 40.9 сая төгрөгөөр илүү байгаа нь орлого төлөвлөгөөнөөс давж биелсэнээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хөрөнгийн чанар байдал, ашиглалтын хугацааг тогтоох арга хэмжээ авах, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, хөрөнгийн ашиглалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Уваа уул аудит ХХК-ийн аудитор Э.Цэвээнсүрэн, Ц.Саранцэцэг, аудиторын туслах Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, Уваа уул Аудит ХХК-д 2023 оны 3 дугаар сарын 03-ний өдрийн 1/133 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 22,520.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 225.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх, байгууллаас зохион байгуулах сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих орлогын 918.5 сая төгрөгийн 55, зарлагын 189.3 сая төгрөгийн 16, нийт 1,107.9 сая төгрөгийн 71 мэдээллийг байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн данс болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 7,340.5 сая төгрөгийн 12 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 184.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрчим хүчний удирдах газар байх үед Сангийн яамнаас Эгийн голын усан цахилгаан станцын төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж 1999 онд 3,731.1 сая төгрөгийн өр төлбөрийн асуудлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,012.6 сая төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 1,499.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2,512.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

5.2.1.Өр төлбөрийн 650.8 сая төгрөг, авлагын 752.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх

5.2.2.Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 96.4 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 5.1. “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн

өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2,512.7 сая төгрөгийн хөрөнгийн чанар байдал, ашиглалтын хугацааг тогтоох арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга										
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 3 нэр төрлийн 2,512.7 сая төгрөгийн хөрөнгийн чанар байдал, ашиглалтын хугацааг тогтоох арга хэмжээ аваагүй байна.	1	2,512,797.5			1	2,512,797.5				
Өр төлбөрийн 650.8 сая төгрөг, авлагын 752.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	1,403,361.8	1	1,403,361.8						
Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 96.4 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байна.	1	96,481.0	1	96,481.0						
Дүн	3	4,012,640.2	2	1,499,842.8	1	2,512,797.5	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 427/А.0150116

Улаанбаатар хот

СНАГ - 2023/107/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд өр төлбөрийн 650,848,952.00 / Зургаан зуун тавин сая найман зуун дөчин найман мянга есөн зуун тавин хоёр/ төгрөг, авлагын 752,512,804.00 /Долоон зуун тавин хоёр сая таван зуун арван хоёр мянга найман зуун дөрөв/ төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирал /Д.Бямбасүрэн/, нягтлан бодогч /Б.Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 426 /АО/СО116

Улаанбаатар хот

СНАГ - 2023 /107/НА -СТА -ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцсээр байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 96,481,026.84 /Ерэн зургаан сая дөрвөн зуун наян нэгэн мянга хорин зургаан төгрөг наян дөрвөн мөнгө/ төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 5.1. "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ТӨБЗГ-аас эд хөрөнгийг шилжүүлэх зөвшөөрөл авч, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гаргасан зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирал /Д.Бямбасүрэн/, нягтлан бодогч /Б.Амараа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-28 Docs

0001080945

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс